Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Наранбулаг сумын Засаг даргын тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Наранбулаг сумын Засаг даргын Тамгын газрын 2025 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1,106,654.7 мянган төгрөгөөр буюу 45.3 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө			
Авлага	770.8	174.7	-596.1
Урьдчилгаа			
Бараа материал	510,873.5	621,467.1	110,593.6
Үндсэн хөрөнгө	1,879,730.5	2,876,387.7	996,657.2
<b>Нийт хөрөнгө</b>	<b>2,391,374.8</b>	<b>3,498,029.5</b>	<b>1,106,654.7</b>
Өр төлбөр	519.8	14,881.8	14,362.0
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	2,390,855.0	3,483,147.7	1,092,292.7
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>2,391,374.8</b>	<b>3,498,029.5</b>	<b>1,106,654.7</b>

Мөнгөн хөрөнгө, урьдчилж гарсан зардлын эхний болон эцсийн үлдэгдэл байхгүй байна.

Авлага дансны үлдэгдэл 174.7 мянган төгрөг болж 596.1 мянган төгрөгөөр буурсан нь хувь хүмүүсээс авах авлага барагдсан байна.

Бараа материалын дансны эцсийн үлдэгдэл 621,467.1 мянган төгрөг болж 110,593.6 мянган төгрөгөөр өссөн нь аж ахуйн материал, бусад хангамжийн материал нэмэгдсэнтэй холбоотой байна.

Үндсэн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл 2,876,387.7 мянган төгрөг болж 996,657.2 мянган төгрөгөөр өссөн нь бусад үндсэн хөрөнгө, барилга байгууламжийн хөрөнгө нэмэгдсэнтэй холбоотой байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 14,881.8 мянган төгрөг болж 14,362.0 мянган төгрөгөөр өссөн нь Нийгмийн даатгалын шимтгэл, түлш халаалт, албан томилолтын зардлын болон байгууллагад төлөх өглөг байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 3,483,147.7 мянган төгрөг болж 1,092,292.7 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

2025 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 650,320.9 мянган төгрөгөөр буюу 34.1 хувиар өссөн байна. Орлого өсөхөд үнэ төлбөргүй хүлээн авсан үндсэн хөрөнгө, бараа материал голлон нөлөөлсөн байна.

Нийт зардал өмнөх оноос 106,337.8 мянган төгрөгөөр буюу 7.8 хувиар өссөн байна. Зарлага өсөхөд цалингийн нэмэгдэл болон үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал голлон нөлөөлжээ.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2025 оны төсвийн төсөлд урсгал зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 1,183,828.7 мянга, нийт зарлагыг 1,183,828.7 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслийг 157,627.0 мянган төгрөгөөр бууруулж 1,026,201.7 мянган төгрөгөөр баталсан байна.

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсвийг 87,751.7 мянган төгрөгөөр нэмэгдүүлж 1,113,953.4 мянган төгрөгөөр тодотгосон байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,113,953.4 мянган төгрөгийн төсөв баталсан нь орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр орон төсвөөс 1,105,551.0 мянга, үндсэн үйл ажиллагааны орлогоос 735.5 мянга, нийт 1,106,286.5 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 1,032,949.3 мянган төгрөгийг зарцуулж, 73,337.2 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна. Мөн нэр данс зөрүүгээр орж ирсэн 250.0 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,032,949.3 мянган төгрөг буюу 93.3 хувьтай байна.

#### Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/мянган төгрөгөөр/	
				Зөрүү	Биелэлт
1	ОН-өөрөө удирдах ёсны байгууллага-70106 Үндсэн үйл ажиллагааны зардал-80101	613,597.9	608,677.9	4,920.0	99.1%
2	ОН-өөрөө удирдах ёсны байгууллага-70106 Баг, хорооны ҮА-ны зардал- 80106	187,810.8	185,164.5	2,646.3	98.5%
3	ОН-өөрөө удирдах ёсны байгууллага-70106 Төрийн өмчийн барилгын тогтмол зардал-80111	46,152.0	42,781.9	3,370.1	92.6%
4	ОН-өөрөө удирдах ёсны байгууллага-70106 Нийтлэг үйлчилгээ-80112	88,800.4	87,950.9	849.5	99%
5	ОН-өөрөө удирдах ёсны байгууллага-70106 Бусад-80918	44,600.0		44,600.0	0
6	ОН-өөрөө удирдах ёсны байгууллага-70106 Ажил олгогчоос олгох тэтгэмж-80802	52,274.7	48,159.3	4,115.4	92.1%
7	ОН-өөрөө удирдах ёсны байгууллага-70106 Орон нутгийн нөөц хөрөнгө -81102	38,500.0	28,463.1	10,036.9	73.9%
8	ОН-өөрөө удирдах ёсны байгууллага-70106 Улсын баяр наадам-82801	20,000.0	20,000.0		100%
9	Байгаль, орчны хамгаалах, нөхөн сэргээх-71413 Байгаль, орчны хамгаалах, нөхөн сэргээх-81701	5,950.7	4,151.7	1,799.0	69.7%
10	Ахмад настны хөгжил хамгаалал-72208 Ахмадын сан-81549	8,600.0	7,600.0	1,000.0	88.3%
		1,106,286.5	1,032,949.3	73,337.2	

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### Аудитын ерөнхий чиглэлийн судалгааны дүн

№	Үзүүлэлт	Төсөв	Гүйцэтгэл	Зөрүү	Тайлбар
					/мянган төгрөг/
1	Программ хангамжийн бүртгэл		5,140.0		Санхүүгийн Acolous, архив бичиг хэргийн программ

2	Унаа, хоолны зардал	0.0	4,980.0	4,980.0	Ажилтнуудад хоолны хөнгөлөлтийг 1 хоногт 10.0 мянган төгрөгөөр тооцон олгож байна.
3	Сургалт, семинар	3,812.8	917.1	2,895.7	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардлаас гарсан.
4	Гадаад томилолт, арга хэмжээ		0.0		Зардал гараагүй.
5	Төрд учирсан хохирлыг барагдуулахтай холбоотой зардал		0.0		Төрд учирсан хохирлыг барагдуулахтай холбоотой зардал гараагүй байна.
6	Орон тооны цомхотгол		0.0		Орон тооны цомхотгол хийгээгүй
7	Хэвлэл, мэдээлэл		0.0		Зардал гараагүй.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт 101,228.6 мянган төгрөгийн орлого бүртгэсэн байна.

Нэмэлт санхүүжилтийн данснаас цалин хөлсний зардалд 857.5 мянга, нийгмийн даатгалын шимтгэлийн зардалд 98.6 мянга, тээвэр шатахууны зардалд 2,172.3 мянга, гэрэл цахилгааны зардалд 2,983.7 мянга, хог хаягдал хортон зайлуулах зардалд 2,395.0 мянга, багаж техник хэрэгсэл зардалд 4,520.0 мянга, урсгал засварын зардалд 3,000.0 мянга, бараа үйлчилгээний бусад зардалд 12,209.0 мянга, хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардалд 2,000.0 мянга, нийт 30,236.1 мянган төгрөгийг зарцуулсан байна. Зарцуулаагүй үлдэгдэл 70,992.5 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.5.3 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тайлант хугацаанд төсөл хөтөлбөр хэрэгжүүлээгүй байна.

### 3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Наранбулаг сумын Засаг даргын тамгын газар нь тайлант онд худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй байна.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Наранбулаг сумын Засаг даргын тамгын газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах

асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахад чиглэсэн зөвлөмж өгөөгүй болно.

Аудитыг Увс аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Т.Намжил гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер М.Бат-Амгалан, дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь нар тус тус хэрэгжүүлсэн.

Наранбулаг сумын Засаг даргын тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Увс аймаг дахь Төрийн аудитын газарт 2026 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн 14 дүгээр албан бичгээр ирүүлсэн.

#### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 1,354,774.6 мянган төгрөгийн 1 хувиар буюу 13,547.7 мянган төгрөгөөс 80 хувиар тооцож 10,838.2 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

Гүйцэтгэлийн шатанд материаллаг байдлыг 2025 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 1,461,112.4 мянган төгрөгийн 1 хувиар буюу 14,611.1 мянган төгрөгөөс 80 хувиар тооцож 11,688.9 мянган төгрөгөөр тогтоосон.

#### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор Наранбулаг сумын Засаг даргын тамгын газрын тухайн хуульд хамаарах зүйл заалтын хүрээнд горим сорил хэрэгжүүлсэн.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил гараагүй болно.

#### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

##### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Наранбулаг сумын Засаг даргын тамгын газар нь тайлант хугацаанд [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд оруулбал зохих 171 мэдээллээс хугацаандаа оруулсан 164 хугацаа хоцроож оруулсан 4, мэдээлээгүй 1, хугацаа болоогүй хүлээгдэж байгаа 2 мэдээлэл байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

#### **4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад бусад хууль тогтоомжтой холбоотой горим сорил хэрэгжүүлээгүй болно.

#### **4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

##### **4.5.1 Завсрын аудитын талаар**

Наранбулаг сумын Засаг даргын тамгын газрын 2025 оны санхүүгийн тайланд завсрын аудит хийгээгүй болно.

##### **4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар зөрчил гараагүй байна.

#### **4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

1. Мал тооллогын цалин, 12 дугаар сард олгосон ажилтнуудын урамшуулал, хөгжлийн бэрхшээлтэй иргэний тооцооллын зөрүү, олон нийтийн цагдаагийн 8 дугаар сарын цалингаас тооцоолсон нийгмийн даатгалын шимтгэлийн мэдээ тайланг буруу гаргаж хүргүүлснийг засуулахаар Нийгмийн даатгалын газарт сумын Засаг даргын тамгын газрын даргын 2026 оны 01 дүгээр сарын 19-ний өдрийн 15 дугаар, 01 дүгээр сарын 09-ний өдрийн 09 дүгээр, 01 дүгээр сарын 06-ны өдрийн 03 дугаар бичгүүдээр хүсэлт хүргүүлсэн байна. Дараагийн аудитаар Нийгмийн даатгалын мэдээ тайланд залруулга хийж, тооцоо нийлсэн эсэхийг шалгах нь зүйтэй гэж үзлээ.
2. Наранбулаг сумын Засаг даргын тамгын газраас Төсвийн Ерөнхийлөн захирагчийн баталсан бүтэц орон тоонд байхгүй 4 багийн сахиулыг гэрээтээр ажиллуулж байна. Дараагийн аудитаар тухайн гэрээт ажилтнуудын орон тоог Төсвийн Ерөнхийлөн захирагчаар батлуулсан эсэхийг шалгах нь зүйтэй гэж үзлээ.

### **5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ**

Аудитаар илэрсэн зөрчилд 1 албан шаардлага өглөө.

#### **5.1 Албан шаардлага**

Наранбулаг сумын Засаг даргын 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар өгсөн Төрийн жинхэнэ албан хаагчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэхэд цалин, урамшуулал олгох журмын 2.2-д “түр орлон гүйцэтгэх хугацаа нь 6 сараас дээш үргэлжлэх бол орлон гүйцэтгэж байгаа албан тушаалын цалингийн 40 хүртэл хувийг түр орлон гүйцэтгэсэн төрийн жинхэнэ албан хаагчид олгоно” гэж заасныг хэрэгжүүлэх зөвлөмж өгснийг хэрэгжүүлэн ажиллаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт “Төсөв нь Улсын болон Аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд чиглэсэн байх бөгөөд төсвийг төлөвлөх, батлах, хэрэгжүүлэх, тайлагнахад дараах зарчмыг баримтална”, 5.1.5 дахь заалтад “хариуцлагатай байх”, Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.3 дахь хэсэгт “Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн хүрээнд хэрэгжүүлсэн ажил, түүний үр дүнг төрийн аудитын байгууллагаас тогтоосон хугацаанд мэдэгдэнэ” гэсэн заалт болон “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Наранбулаг сумын Засаг даргын 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллахыг албан шаардлага болгов.

Дээрх албан шаардлагын биелэлтийг Увс аймаг дахь Төрийн аудитын газарт 2026 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

### Залруулсан алдаа:

Наранбулаг сумын Засаг даргын тамгын газар нь 12,133.8 мянган төгрөгийн гүйлгээг шууд зардалд бүртгэсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэгт “Аж ахуйн нэгж байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккрузл сууриар хөтөлнө” гэсэн заалт болон толилуулга батламж мэдэгдлийг хангахгүй байсан тул залруулга хийлгэлээ.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Нягтлан бодох бүртгэлээ аккрузл сууриар хөтлөөгүй	1	12,133.8	1	2,133.8			1	2,133.8				
Дүн	1	12,133.8	1	22,133.8			1	22,133.8				

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Өмнөх оны аудитаар өгсөн зөвлөмж хэрэгжүүлээгүй	1	0.0			1	0.0						
Дүн	1	0.0			1	0.0						

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Дүн								
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн								
Нийт дүн								

АУДИТЫН ТАЙЛАН

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

БЭЛТГЭСЭН:

АХЛАХ АУДИТОР



/М.БАТСУУРЫ/

/М.БАТ-АМГАЛАН/

/Т.НАМЖИЛ/

2026 оны 02 дугаар сарын 23-ны өдөр

**АЛБАН ШААРДЛАГЫН БҮРТГЭЛ,  
ХЯНАЛТЫН ХУУДАС**

**А. Албан шаардлагын төсөл бэлтгэж, баталгаажуулах үеийн бүртгэл, хяналт**

1.Ерөнхий мэдээлэл

1.1 Аудитын нэр	Увс аймгийн Наранбулаг сумын ЗДТГ-ын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит	1.2 Аудитын код	УВА-2026/063/НА-СТА-ТШЗ
-----------------	------------------------------------------------------------------------------------------------------------------------	-----------------	-------------------------

1.3 Аудит хийсэн үндэслэл	Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1	1.4 Аудитын төрөл	Санхүүгийн тайлангийн аудит
---------------------------	-------------------------------------------------------------------------------------------------------------------------	-------------------	-----------------------------

1.5 Албан шаардлагын дугаар		1.6 Огноо	2026.02.12	1.7 Мөнгөн дүн /төгрөгөөр/	
-----------------------------	--	-----------	------------	----------------------------	--

1.8 Албан шаардлага өгөх үндэслэл	Алдаа, зөрчлийн товч утга	Наранбулаг сумын Засаг даргын 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар өгсөн Төрийн жинхэнэ албан хаагчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэхэд цалин, урамшуулал олгох журмын 2.2-д "түр орлон гүйцэтгэх хугацаа нь 6 сараас дээш үргэлжлэх бол орлон гүйцэтгэж байгаа албан тушаалын цалингийн 40 хүртэл хувийг түр орлон гүйцэтгэсэн төрийн жинхэнэ албан хаагчид олгоно" гэж заасныг хэрэгжүүлэн ажиллах зөвлөмж өгснийг хэрэгжүүлэн ажиллаагүй байна.			
	Алдаа, зөрчлийн ангилал	Хууль, тогтоомжийг хэрэгжүүлээгүй			
	Журмын заалт (4.2-оос аль тохирохыг оруулах)	4.2.1.11 дэх заалтад "Хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал"			
	Зөрчсөн эрх зүйн актын	Нэр	Төсвийн тухай хууль, Төрийн аудитын тухай хууль		
		Заалт	Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт "Төсөв нь Улсын болон Аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд чиглэсэн байх бөгөөд төсвийг төлөвлөх, батлах, хэрэгжүүлэх, тайлагнахад дараах зарчмыг баримтална", 5.1.5 дахь заалтад "хариуцлагатай байх", Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.3 дахь хэсэгт "Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн хүрээнд хэрэгжүүлсэн ажил, түүний үр дүнг төрийн аудитын байгууллагаас тогтоосон хугацаанд мэдэгдэнэ"		
Үндэслэл болгосон эрх зүйн актын	Нэр	Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх заалт, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.10 дэх заалт			
	Заалт	4.2.1-д "Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана", 4.2.1.10-д "Аудитаар илэрсэн			

		алдаа, зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол"
--	--	-------------------------------------------------------------------------------------

1.9 Зөрчил барагдуулах хэлбэр /Төгрөгөөр/	Улсын төсвийн дансанд	1.10 Зөрчил барагдуулах огноо
	Орон нутгийн төсвийн дансанд	
	Тухайн байгууллагын дансанд	
	Зөрчил арилгах	
		2026.04.30

2. Үндэслэл болгосон гол нотлох баримтын талаарх мэдээлэл


№	Нотлох баримтын нэр төрөл	Дугаар	Огноо	Тайлбар
1	Өмнөх оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан		2025.02.25	Өмнөх оны санхүүгийн тайлангаар зөвлөмж өгсөн.
2	Холбогдох анхан шатны баримтын түүвэр		2025.02.12	Тушаал шийдвэр, цалингийн цэс

3. Аудитын баг болон хариуцагчийн талаарх мэдээлэл


№	Аудитын багийн		Хариуцагч			
	Албан тушаал	Овог нэр	Байгууллагын нэр	Албан тушаал	Овог нэр	Холбоо барих хаяг, утас
1	Ахлах аудитор	Т.Намжил	Наранбулаг сумын ЗДТГ	Дарга	П.Дашдорж	88765299
				Нягтлан бодогч	О.Ганчимэг	80310083

Албан шаардлага бэлтгэх үеийн чанарын хяналт

4.1 Чанарын хяналт хийсэн тэмдэглэл

№	Албан тушаалтан	Огноо	Чанарын хяналтаар өгсөн санал зөвлөмж	Гарын үсэг
1	Аудитын менежер М.Бат-Амгалан	2026.02.21	—	
2	Дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь	2026-02.21	—	

4.2 Албан шаардлагыг хэвлэмэл хуудсанд хэвлэх зөвшөөрөл

№	Албан тушаал	Овог нэр	Огноо	Гарын үсэг
1	Дарга, тэргүүлэх аудитор	М.Батсуурь	2026.02.21	

4. Албан шаардлагыг баталгаажуулж, хүргүүлэх үеийн баримтжуулалт

№	Үзүүлэлт	Мэдээлэл оруулах хэсэг	Тайлбар	
1	Албан шаардлагыг хүргүүлсэн албан бичгийн	Огноо		
		Дугаар		
2	Албан шаардлагыг хүлээлгэн өгсөн	Огноо	2026.02.12	
		Ажилтны	Овог нэр	Т.Намжил
			Албан тушаал	Ахлах аудитор
3	Албан шаардлагыг хүлээн авсан	Байгууллагын нэр	Наранбулаг сумын ЗДТГ	
		Ажилтны	Овог нэр	О.Ганчимэг
			Албан тушаал	Нягтлан бодогч
4	Албан шаардлагын хэрэгжилтийг хариуцах	Газрын нэр	Наранбулаг сумын ЗДТГ	
		Ажилтны	Овог нэр	П.Дашдорж
			Албан тушаал	Дарга
5	Тооцоолсон зөвшөөрүүлсэн үр өгөөж	Санхүүгийн	Тоо	
			Дүн	
		Санхүүгийн бус үр өгөөжийн тоо		



УВС АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 24 өдөр

01/10/А 2060412  
Дугаар МБА-2026/063/НА-СТА-ТшЗ

Улаангом

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Наранбулаг сумын Засаг даргын тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Наранбулаг сумын Засаг даргын 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар өгсөн Төрийн жинхэнэ албан хаагчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэхэд цалин, урамшуулал олгох журмын 2.2-д “түр орлон гүйцэтгэх хугацаа нь 6 сараас дээш үргэлжлэх бол орлон гүйцэтгэж байгаа албан тушаалын цалингийн 40 хүртэл хувийг түр орлон гүйцэтгэсэн төрийн жинхэнэ албан хаагчид олгоно” гэж заасныг хэрэгжүүлэн ажиллах зөвлөмж өгснийг хэрэгжүүлэн ажиллаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт “Төсөв нь Улсын болон Аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд чиглэсэн байх бөгөөд төсвийг төлөвлөх, батлах, хэрэгжүүлэх, тайлагнахад дараах зарчмыг баримтална”, 5.1.5 дахь заалтад “хариуцлагатай байх”, Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.3 дахь хэсэгт “Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн хүрээнд хэрэгжүүлсэн ажил, түүний үр дүнг төрийн аудитын байгууллагаас тогтоосон хугацаанд мэдэгдэнэ” гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх заалтад “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, акт тогтоох журам”-ын 4.2.1-д “Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана”, 4.2.1.10-д “Аудитаар илэрсэн алдаа, зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол” гэж заасныг үндэслэн ШААРДАХ нь:

1. Наранбулаг сумын Засаг даргын 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллаж биелэлтийг нотлох баримтын хамт 2026 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Увс аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.

2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Наранбулаг сумын Засаг даргын тамгын газрын дарга П.Дашдорж, нягтлан бодогч О.Ганчимэг нарт даалгав.
3. Албан шаардлагыг хүлээн зөвшөөрөөгүй тохиолдолд Захиргааны ерөнхий хуулийн 92 дугаар зүйлийн 92.1 дэх хэсэгт заасны дагуу гомдол гаргах эрхтэй.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АХЛАХ АУДИТОР



Т.НАМЖИЛ

АУДИТЫН МЕНЕЖЕР



М.БАТ-АМГАЛАН

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

М.БАТСУУРЬ